



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

160 /160/

2021.10.20

ҮЙЛ ЯВДАЛ

ЭХНИЙ САРЫН ДҮНГ ГАРГАЖ АЖИЛЧДАА УРАМШУУЛАВ



Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл нь Ерөнхий захирлаас эхлэн бүх ажилчдын идэвх чармайлт, ажлын үр дүнг бодитойгоор үнэлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ажлыг дүгнэх журам гарган хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд нь эхний сарын дүнгээ гаргаж, ажилтан алба хаагчдаа урамшууллаа.

Тус арга хэмжээ өчигдөр "Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-ын харьяа "Соёмбот" цэвэр усны үйлдвэрт болж өнгөрсөн юм. Ажлаа хийх явцад удирдлагууд нь ирж тухайн сард шилдэг тэргүүний байж бусдыгаа хошуучилсан ажилтан албан хаагчдаа урмын үгийн хамт урамшуулахын зэрэгцээ ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн хэсэгчилсэн

тоглолтыг сонирхуулав.

Хэрэглэгчдийн найдвартай түншболохуйцэвэрүсгүйлдвэрлэх болсон тус үйлдвэр нь цэвэр усны үйлдвэрлэл явуулах стандартад нийцсэн тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж эхлээд байгаа юм. Түүнчлэн тус үйлдвэрийн хамт олон Төмөр замын бүтээн байгуулалт, Нийслэлийн иргэдийг утаагүй түлшээр хангагч "Таван

толгой түлш" компани, Засгийн газраас Залуучуудын хөдөлмөрийг дэмжих "Оролцоо" төсөл, ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ-2021" хээрийн сургууль, БНӨСУ-д үүрэг гүйцэтгэх 11 дүгээр ээлжийн бие бүрэлдэхүүн болон БХЯ-ны харьяа агентлаг, байгууллага, 40 гаруй аж ахуй нэгж байгууллагуудыг хүнсний аюулгүй байдлыг хангасан цэвэр усаар ханган ажиллаж байна.

Түүхэнд энэ өдөр

1965 он:

БНМАУ-ын АЦХЭЯ-ны сайд бөгөөд Ардын армийн командлагчийн н261 тоот тушаалаар зенит пуужингийн 75 дугаар тусгай дивизион нийслэл хотыг агаараас халхлах байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх болов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 6	🌧️ -10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,849.00	2,851.00
EUR 🇪🇺	3,312,0	3,322,0
CNY 🇨🇳	442,07	443,08
RUB 🇷🇺	39,50	40,70
JPY 🇯🇵	24,69	25,19
KRW 🇰🇷	2,36	2,45

ЗУРХАЙ

2021.10.20 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 15/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн
Наран ургах, шингэх:
07.19-17.55
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал:
Уул

Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөө сайн ба могой, морь жилтнээ сөрөө муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лус тахиx, мал арилжих, гэр бүрэхэд сайн.

Цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Хяруу унах улирал (9 цаг 19 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТАД 50 АХЛАГЧ ХАМРАГДЛАА



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн "Рот /батареи-ын ахлагчийн дамжаа"-г 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс нэг сарын хугацаатайгаар амжилттай зохион байгууллаа.

Батлан хамгаалахын сайдын тушаалаар зохион байгуулсан 5 дахь удаагийн дамжаанд Зэвсэгт хүчний 23 нэгтгэл, анги, салбарын 50 ахлагч суралцаж, амжилттай төгсөөд байна.

Энэхүү дамжааны төгсөлтийн ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр, тус сургуулийн Сургалтын хэлтсийн

дарга, хурандаа Г.Болор болон албаны бусад бүрэлдэхүүн оролцлоо.

Дамжаанд хамрагдсан ахлагч нар батлагдсан сургалтын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу манлайлах чадвар, цэргийн алба, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах болон ерөнхий тактик, жагсаалын бэлтгэл, биеийн тамирын бэлтгэлээр нийт 4 багц цагийн хичээлийг танхимын хэлбэрээр судалсан бөгөөд хоногийн манааны үүрэг гүйцэтгэх, судалгааны ажлыг боловсруулах, илтгэх зэргээр өөрсдийн ур чадвараа ахиуллаа.

Ахлах ахлагч М.БАЯРСҮХ

МОНГОЛ УЛСЫН РЕКОРДЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Энэ сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан "Багахангай марафон-2021" Улсын аварга шалгаруулах тэмцээнд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн тэргүүн ахлагч Б.Баттулга, Олон улсын хэмжээний мастер, ахлах ахлагч Ч.Батжаргал нар 5*10 км-ын буухиа гүйлтийн төрөлд тэргүүн байр эзэлж, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн

шагналаар шагнууллаа.

Мөн ОУХМ ахлах ахлагч Ч.Батжаргал 6 цагийн гүйлтийн төрөлд амжилттай оролцож, 72 км 686 метрийн амжилтаар тэргүүн байр эзлэн Монгол Улсын рекордыг шинэчлэн тогтоолоо. Ингэснээр ахлах ахлагч Ч.Батжаргал Монголын хэт холын гүйлтийн төрөл болох 12 болон 6 цагийн рекордыг эзэмшиж байна.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
333.393 +1303

ЭДГЭРСЭН
446,326 +6710

НАС БАРСАН
1501 +18

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5720 +98

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
194

ЭДГЭРСЭН
5416

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт:242,324,272

Эдгэрсэн

Нийт:219,670,460

Нас барсан

Нийт:4,928,811

Цахим шууданд

ТУСГАЙ РОТЫН ЗАХИРАГЧ НАРЫН ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



2022 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн болон байлдааны бэлэн байдлын төлөвлөгөөнүүдийг батлуулах гэсэн үндсэн 4 зорилт дэвшүүлэн, лекц, асуудал дэвшүүлж, харилцан ярилцах, үзүүлэн таниулах, санал асуулга явуулах аргачлалаар зохион байгууллаа.

Цугларалтаар байгууламжийн дарга, тусгай ротын захирагч, холбооны салааны захирагч болон

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Ангийн харьяа байгууламж, тусгай ротын удирдах бүрэлдэхүүний "Заах арга зүйн цугларалт"-ийг 2021 оны 10 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд ангийн байрлалд зохион байгуулав.

Цугларалтыг Зэвсэгт хүчний 2021-2022 оны сургуулийн жилд анги, салбарын сургалт бэлтгэл, байлдааны бэлэн байдлыг төлөвлөх, жигдрэлт, штабын бэлтгэл, арга зүйг боловсронгуй болгож, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх гэсэн зорилгын хүрээнд хэд хэдэн сэдвийн хүрээнд явуулав. Тодруулбал, ангийн гүйцэтгэх үүргийн жагсаалттай нийцүүлэн нэгдсэн болон хамтарсан байлдааны ажиллагаанд оролцох, байлдааны дэмжлэг үзүүлэх, штабын бэлтгэл, салбарын жигдрэлтийн зохион байгуулалт



арга зүйг боловсронгуй болгож, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, цэргийн алба хаагчдад бие даан сурах арга зүй эзэмшүүлэх, тэдний ухамсар, сурах идэвхийг нэмэгдүүлэх замаар мэргэшсэн цэргийн алба хаагчдыг бэлтгэх зэрэг болно. Мөн 2021-

жолооч албан тушаалтнуудыг хамруулсан нийт 33 цэргийн алба хаагч ангийн захирагчаар батлуулсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хичээл сургуулийг гурван бүлэгт хуваарилан турмилогдсон багш нар сургалтыг явуулсан юм.

Ахмад З.АНХБАЯР

таны сонорт

ХӨДӨЛГӨӨНИЙ ДУТАГДЛААС СЭРГИЙЛЖ ӨГЛӨӨНИЙ "ТАВАТА"-Д НЭГДЭЦГЭЭ

21 зууны хамгийн аюул тахал бол хөдөлгөөний дутагдал мөн таргалалт гэдэгтэй хүн төрөлхтөн эвлэрээд байна. Энэ бүгд нь шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлөөс эхлээд хувь хүний хийдэг ажил мэргэжилтэй холбоотой юм. Ялангуяа оффис ажил эрхэлж буй хэн бүгд хөдөлгөөний дутагдалд орох нь элбэг.

Тэгвэл энэ хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх

үүднээс БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооноос долоо хоног бүрийн даваа, лхагва, баасан гаргуудад өглөө 06.30-08.00 цагийн хооронд "Tabata" дасгалд нэгдэхийг уриалж байна.

"Tabata" дасгал нь богино хугацааны эрчимжүүлсэн "Cardio" дасгалуудын нэг бөгөөд хамгийн сайн өөх шатаах, биеийн бүх булчинг

чангалах (хөл, өгзөг, гар, мөр, хэвлий) дасгалууд багтдаг аж.

Иймд суугаа ажил эрхэлдэг хэн бүхэн өглөөний "ТАВАТА" дасгалд нэгдэж хөдөлгөөний дутагдлаас сэргийлье.

Дасгалын "Алдар" спорт хороо нийтийн биеийн тамир, спорт тоглоомын албаны дарга, хошууч Д.Цэрэнбат багшилж байгаа юм.



ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА

Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд, тэдгээрийн алба хаагчид, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн баг, цэргийн ажиглагч болон штабын офицер, ахлагч нарын дунд сэдэвчилсэн "Шилдэг лого", "Шилдэг зурагт самбар", "Шилдэг богино хэмжээний бичлэг" шалгаруулах уралдааныг зарласан байна.

Уралдааны зорилго нь монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсэн 20 жилийн түүх, ач холбогдол, оролцоог түгээн дэлгэрүүлэх, үе үеийн энхийг сахиулагчдын байгуулсан амжилт, гавьяа зүтгэлийг алдаршуулахад чиглэгдэнэ.

Уралдааны ерөнхий шаардлага:

- Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний

20 жилийн ойн утга санааг илэрхийлсэн үндсэн агуулга, сэдвийн хүрээнд бүтээгдсэн байх;

- Сэдвийн хүрээнд өөрийн санаа бодлоо чөлөөтэй дүрслэн харуулах, илэрхийлэх;

- Уралдаанд нэг уран бүтээлч хэдэн ч дизайны шийдэлтэйгээр оролцож болно;

- Бүтээлийг хэсэгчлэн болон бүтнээр бусад эх сурвалжаас хуулбарлаагүй, зохиогчийн эрх зөрчөөгүй байх;

- Хугацаа хожимдсон, тавигдсан шаардлагыг хангаагүй бүтээлийг хүлээн авахгүй.

Уралдааны тусгай шаардлага:

1. "ШИЛДЭГ ЛОГО"

- Лого нь энхийг сахиулах ажиллагааны түүх, үйл ажиллагааны онцлог, уламжлал, шинэчлэлийн утга санааг бэлгэдсэн дөрвөөс дээшгүй элемент агуулсан, гурваас ихгүй өнгө хосолсон, өгүүлэмжтэй утга агуулга бүхий уран сайхны бүтээл байх;

- Монгол Улс болон НҮБ-ын далбаа орсон байх;

- 20 жилийн ойн тоо орсон байх;

- Adobe Photoshop, In Design, Corel Draw зэрэг мэргэжлийн, зориулалтын программ дээр болон аргаар зурж бүтээсэн байж болно;

- Монгол бичгийн эвхмэл болон бичмэл хэлбэрээр байж болно;

- Логоны дизайн нь



голлох өнгөний дагуу зохимжтой харагдахуйц байж, жижгээс том хүртэл хэмжээг нь өөрчилж болохоор зохиох;

- Лого нь видео, сурталчилгааны самбар, сонин сэтгүүл, албан бланк, ил захидал, сурталчилгааны материал, зурагт хуудас, даавуун болон бусад материалууд дээр хэвлэгдэх боломжтой байх;

- Лого нь өндөр нягтралтай (300 pixels/inch-с дээш) байх;

- Логоны дизайн нь хар, цагаан болон өнгөт гадаргуу дээр хэвлэхэд тохиромжтой байх;

- Логог эх бэлтгэлийн программ дээр бэлтгэхдээ өнгөний тохиргоог CMYK -ээр хийх;

- Логоны зураглал бүр нь тодорхой утга санааг агуулсан байх, тэдгээрийг дараах шаардлагын дагуу тайлбарлаж бичсэн байх;

А. "ТАЙЛБАР" гэж гарчиглах;

Б. Логоны зүйл бүрийг дугаарлах (1, 2, 3, ...);

В. Дугаарласан зүйлийн утга, бэлгэдлийг товч, тодорхой, найруулга зүйн алдаагүй, зөв бичгийн дүрмийн дагуу Arial фонтоор, 12pt өндөр, 1.0 мөр хоорондын зайтай, А4 цаасан дээр, баруун, дээд, доод талаас 2 см, зүүн талаас 3 см зай авч бичнэ;

Г. Тайлбар дууссаны дараа анги, цол, овог нэрийг тодорхой бичнэ;

2. "ШИЛДЭГ ЗУРАГТ САМБАР"

- Зурагт самбар нь энхийг сахиулах ажиллагааны түүх, үйл ажиллагааны онцлог, уламжлал шинэчлэлийн утга санааг бэлгэдсэн, онцлох үйл явдлыг харуулсан өгүүлэмжтэй утга агуулга бүхий уран сайхны бүтээл байх;

- Adobe Photoshop, In Design, Corel Draw зэрэг мэргэжлийн, зориулалтын программ дээр болон аргаар зурж бүтээсэн байж болно;

- Монгол бичгийн эвхмэл болон бичмэл хэлбэрээр байж болно;

- Зурагт самбарын дизайн нь голлох өнгөний дагуу зохимжтой харагдахуйц байх;

- Зурагт самбарыг сурталчилгааны самбар, сонин сэтгүүл, ил захидал, сурталчилгааны материал, зурагт хуудас, даавуун болон бусад материалууд дээр хэвлэгдэх боломжтой байх;

- Зурагт самбар нь өндөр нягтралтай (300 pixels/inch-с дээш) байх;

- Зурагт самбарыг эх бэлтгэлийн программ дээр бэлтгэхдээ өнгөний тохиргоог CMYK-ээр хийх.

3. "ШИЛДЭГ БОГИНО ХЭМЖЭЭНИЙ БИЧЛЭГ"

- Богино хэмжээний бичлэг нь энхийг сахиулах ажиллагааны түүх, үйл ажиллагааны онцлог, уламжлал шинэчлэлийн утга санаа, онцлох үйл явдлыг бэлгэдсэн өгүүлэмжтэй утга агуулга бүхий уран сайхны бүтээл байх;

- Ямар ч төрийн видео хийх аппликейшн ашиглаж болно;

- Бүтээлд зураг, график, монгол бичгийн эвхмэл болон бичмэл хэлбэр байж болно;

- Богино хэмжээний бичлэгт орж буй зураг, дүрслэл нь өндөр нягтралтай байх;

- Богино хэмжээний бичлэгийн үргэлжлэх хугацаа 2-3 минут байх;

- HD форматтай байх;

- Дуу, дүрсний өндөр чанартай байх зэрэг тусгай шаардлага тавигдана.

Та бүхнийг уралдаанд идэвхтэй оролцохыг уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

ДҮҮРГҮҮДИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН БАЙР ХААНА БАЙРЛАЖ БАЙНА ВЭ?

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын А/721 тоот захирамжийн дагуу нийслэлийн есөн дүүрэгт 10 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд эрүүл мэндийн

үзлэг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

Цар тахалтай холбоотойгоор цэрэг татлагын байрыг тусгайлан бэлтгэсэн бөгөөд УОК-

оос гаргасан халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллах бөгөөд дүүргүүдийн цэрэг татлагын байр хаана байрлаж байгаа талаарх мэдээллийг хүргэж байна.

Баянгол дүүрэг-"Оюуны ундраа" цогцолбор сургууль /96 дугаар сургууль/

Баянзүрх дүүрэг- Ерөнхий боловсролын 14 дүгээр дунд сургууль

Сүхбаатар дүүрэг-Ерөнхий боловсролын 31 дүгээр дунд сургууль

Сонгинохайрхан дүүрэг-"Өнөр" цогцолбор сургууль /83 дугаар дунд сургууль/

Хан-Уул дүүрэг-Ерөнхий боловсролын 34 дүгээр дунд сургууль

Чингэлтэй дүүрэг- Ерөнхий боловсролын 34 дүгээр дунд сургууль

Налайх дүүрэг-Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв

Багануур дүүрэг- "Гүн галуутай" цогцолбор сургууль

Багахангай дүүрэг -"Хангай" цогцолбор сургууль